



**МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ**

---

**Текстил. Амны даавуун хаалт  
Техникийн шаардлага**

**MNS 6828:2020**

**Албан хэвлэл**

**Стандарт, хэмжил зүйн газар  
Улаанбаатар хот  
2020 он**

COVID-19 ВИРУСЭЭС ХАМГААЛАХТАЙ ХОЛБОГДУУЛАН ОЛГОВ.  
Стандарт, хэмжил зүйн газар. Стандартын мэдээлэл, лавлагaa, сургалтын үндэсний төв.  
Худалдан борлуулхыг хориглоно. 2020-03-17

## Өмнөх үг

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон улсын стандартчиллын байгууллагын жинхэнэ гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллагуудтай хамтран үндэсний стандарт боловсруулах ажлыг зохион байгуулдаг.

Үндэсний стандартын төсөл боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг бөгөөд техникийн хороодоор хэлэлцэж дэмжсэн, зөвшилцэлд хүрсэн стандартын төслийг Стандарт, хэмжил зүйн газрын даргын тушаалаар баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг СХЗГ-ын даргын 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/55 дугаар тушаалаар баталсан дараах бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг:

- С.Янжинсүрэн /Шадар сайдын зөвлөх/,
- Р.Бадмаанямбуу /Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнгийн Ноос, ноолуурын сорилтын төвийн захирал, Текстилийн стандартчиллын ТХ 16-ны дарга/,
- Ч.Хатанбаатар /СХЗГ-ын СМЛСҮТ-ийн дарга/,
- Н.Сувдмаа /ХӨСҮТ-ийн эрт сээрэмжлүүлэг, хариу арга хэмжээ авах нэгжийн дарга/, Б.Наарандолгор /ХХААХҮЯ-ны ХҮХБЗГ-ын мэргэжилтэн/,
- Г.Ган-Эрдэнэ /ХХААХҮЯ-ны ЖДҮҮХХБЗГ-ын мэргэжилтэн/,
- Д.Тунгалаг /Оёдлын салбарын мэргэжлийн нэгдсэн холбооны тэргүүн/,
- Ц.Бурмаа /СХЗГ-ын СТУБГ-ын ахлах мэргэжилтэн/,
- Ч.Пүрэвдулам /СХЗГ-ын СТУБГ-ын мэргэжилтэн/ нар боловсруулав.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төв, ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургууль, ШУТИС-ийн Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн, Оёдлын салбарын мэргэжлийн нэгдсэн холбооноос тус тус санал авсан.

## Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө- 46А

Улаанбаатар хот –13343,

Шуудангийн хайрцаг- 48

Утас: 263860, 266754

Факс: +976-11-458032

E-mail: [standardinform@masm.gov.mn](mailto:standardinform@masm.gov.mn)

[www.masym.gov.mn](http://www.masym.gov.mn) [www.estandard.gov.mn](http://www.estandard.gov.mn)

## © СХЗГ, 2020

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэжмлэлийн тухай хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагчхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 13.340.20; 59.080.01

Текстил. Амны даавуун хаалт. Техникийн шаардлага Textile. Cloth face mask. Technical requirement	MNS 6828 :2020
---	----------------

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн С/09 дүгээр тушаалаар батлав.

Энэ стандартыг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн мөрдөнө.

## 1 Зорилго

Агаарын бохирдол, амьсгалын замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах зориулалт бүхий олон удаа хэрэглэх амны даавуун хаалтны чанарын үзүүлэлт, шаардлагыг тогтооход оршино.

## 2 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь олон удаа хэрэглэх амны даавуун хаалтны материалын чанар, аюулгүйн шаардлагыг тогтоох, хаяглах, савлах, хадгалах, тээвэрлэхэд хамаарна.

## 3 Норматив эшлэл

Энэ стандартад эш татаж хэрэглэсэн дараах стандарт болон норматив техникийн баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийн хамгийн сүүлчийн хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

*MNS 6295:2011, Нэхмэл. Нэхмэл, сүлжмэл, оёмол бүтээгдэхүүний аюулгүй байдлын нийтлэг шаардлага,*

*MNS ISO 4915:2012, Нэхмэл. Хатгацын төрөл. Ангилал ба нэр томьёо,*

*MNS ISO 4916:2011, Нэхмэл. Оёдлын төрөл - Ангилал ба нэр томьёо,*

*GB 15979-2005, Нэг удаагийн хэрэглээний эрүүл ахуйн ариун бүтээгдэхүүний стандарт,*

*GB/T 24218.2-2009, Нэхээсгүй даавуунд хийх туршилтын арга 1-р хэсэг: Нэгж талбайн чанарыг тодорхойлох,*

*FZ/T 64005-2011, Нэхээсгүй даавууны техникийн үзүүлэлт.*

## 4 Нэр томьёо, тодорхойлолт

### 4.1

**олон удаа хэрэглэх амны даавуун хаалт** (цаашид “амны хаалт” гэх) гадна орчин болон орчны халдварт, бохирдоос хамгаалах, тусгаарлах, эрүүл ахуй, халдварт хамгааллыг сахиж хамар амыг хааж, дахин давтан хэрэглэх хэрэгсэл

### 4.2

#### даавуу

байгалийн болон химийн ширхэгтээр нэхэх болон сүлжих аргаар үйлдвэрлэсэн эд

## 5 Техникийн шаардлага

**5.1** Амны хаалтны их биеийн зохион бүтээлт, загвар нь амьсгалах үед ам болон хамраас хөндий байх ба гадар, дотор давхаргын дунд нэмэлт нүүрсэн шүүлтүүр сольж хийх боломжтой задгай уутан давхартай байж болно.

1-Р ТАЙЛБАР: Амны хаалтны дотор талын материал нь цагаан, цайвар, гадна талын материал нь дурын өнгөтэй байж болно.

2-Р ТАЙЛБАР: Амны хаалтны загварыг Хавсралтаас харна уу.

**5.2** Амны хаалтыг батлагдсан эх загвар, техникийн шаардлагын дагуу үйлдвэрлэлийн зохих технологиор үйлдвэрлэнэ.

**5.3** Амны хаалтны чихэнд тогтоогчийг сунамтгай материалыаар хийсэн байна.

**5.4** Амны хаалт нь чийг шингээлт, агаар нэвтрүүлэлт сайтай, эрүүл ахуйн шаардлага хангасан хэлбэр, хийцтэй байна.

**5.5** Амны хаалт нь хамрын даруулгатай байж болно. Хамрын даруулга нь уян, хөнгөн цагаан материалтай байна.

**5.6** Амны хаалтны хамрын уян даруулга нь арьсанд аливаа цочроо, шархлаа үүсгэх хурц ирмэггүй, их биеийн нүүр, ам, хамарт хүрэлцэх хэсгийн материал нь харшил үүсгэхээргүй бүтэц, агууламжтай байна.

**5.7** Амны хаалтыг угааж хэрэглэхэд агшиж, сунахгүй, нүүрний хэлбэрт тохиромжтой уян хатан байх зорилгоор дотор талыг нэхмэл даавуугаар, гадна талыг сүлжмэл даавуугаар хийнэ.

**5.8** Амны хаалтанд орох нэхмэл болон сүлжмэл даавуун материалд тавих шаардлага нь 1 ба 2-р хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

#### 1-р хүснэгт - Дотор талын материалын чанар, аюулгүйн үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр		Хэмжих нэгж	Зөвшөөрөх хэмжээ
1	Ширхэгтийн бүрэлдэхүүн	Хөвөн	%	100
2	Даавууны 1м <sup>2</sup> -ийн жин	Гадар	г/м <sup>2</sup> , багагүй	120
		Дотор	г/м <sup>2</sup> , багагүй	120
3	Зузаан		мм, ихгүй	0,5
4	Нэхээсний няйт	Тууш	10 см дэх суурь утасны тоо, багагүй	240
		Хөндлөн	10 см дэх хөндлөн утасны тоо, багагүй	200
5	Будгийн тогтворт	Угаалгад	Балл	4-5
6	Даавууны агшилт, суналт (5 удаагийн угаалтын дараах)	Тууш	%, ихгүй	±3
		Хөндлөн		±3
7	Агаар нэвтрүүлэлт	Агаарын эзлэхүүн	л/цаг*см <sup>2</sup> , багагүй	200
		Агаарын хэмжээ	мм/с, багагүй	100
8	Формальдегидийн хэмжээ		мг/кг, ихгүй	75

**2-р хүснэгт - Гадна талын материалын чанар, аюулгүйн үзүүлэлт**

№	Үзүүлэлтийн нэр		Хэмжих нэгж	Зөвшөөрөх хэмжээ
1	Ширхэгийн бүрэлдэхүүн		Байгалийн ба химийн ширхэгт	%
2	Даавууны 1м <sup>2</sup> -ийн жин		г/м <sup>2</sup> , багагүй	220
3	Зузаан		мм, ихгүй	0.8
4	Будгийн тогтворт		Балл, багагүй	4
5	Даавууны агшилт, суналт (5 удаа угаасны дараах)		% , ихгүй	±3
			Хөндлөн	±3
6	Агаар нэвтрүүлэлт		Агаарын эзлэхүүн	л/цаг*см <sup>2</sup> , багагүй
			Агаарын хэмжээ	мм/с, багагүй
7	Формальдегидийн хэмжээ		мг/кг, ихгүй	100
				75

**5.9 Амны хаалтны хэмжээ нь 3-р хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.**

**3-р хүснэгт - Амны хаалтны хэмжээ**

№	Ангилал	Хэмжээ, см	Зөвшөөрөх хэлбэлзэл, см
1	Их бие	Урт 18,0 x Өргөн 9,5 x өндөр 13	±0,5
	Хүүхдэд зориулсан	Урт 12,0 x Өргөн 7,5 x өндөр 9,5	±0,5
2	Чихэнд тогтоогч	Урт нь 8 см-ээс багагүй (резинь суналтаас хамааран 15-18 см гэж солих)	±0,5

**5.10 Оёдлын жигд байдал**

- а) Амны хаалтны бүрдэл хэсгийг оёх хатгац, оёдлын төрөл нь MNS ISO 4916:2011, MNS ISO 4915:2012 стандартад нийцсэн байна.
- б) Амны хаалтны нэгтгэх бүх оёдол 1,0 см тутамд (3,5-4) ширхэг хатгацтай байна.
- с) Ил оёдол нь тэгш, алгасаагүй, шигээгүй, тунараагүй, муруйгүй байна.

**6 Дээж авах, шалгах арга**

**6.1 Дээж авах**

Нэг төрлийн даавуугаар хийсэн амны хаалтыг нэг багц гэх бөгөөд нийт бүтээгдэхүүнээс гурван ширхгээс багагүйг түүвэрлэх аргаар дээж болгон авна.

**6.2 Гадна байдал**

Амны хаалтны гадна байдлыг харах, үнэрлэх мэдрэхүйгээр тодорхойлно.

**6.3 Хэмжээг шалгах**

Амны хаалтны их биеийн хэмжээ, чихэнд тогтоогчийн уртыг мм-ийн хуваарьтай хэмжих хэрэгслээр хэмжинэ.

**7 Савлалт, хаяглалт, хадгалалт, тээвэрлэлт**

**7.1 Амны хаалтыг нэг болон хэд хэдэн ширхгээр нийлэг уутанд савлаж дараах мэдээллийг агуулсан шошго дагалдуулсан байна. Үүнд:**

- Үйлдвэрийн нэр, хаяг;
- Бүтээгдэхүүний нэр;
- Багцын дугаар;
- Хэрэглэх болон арчилгааны заавар;
- Ширхэгийн бүрэлдэхүүн;

- Зурган тайлбар,
- Стандартын дугаар;
- Үйлдвэрлэсэн огноо;
- Амны хаалтыг хэрэглэхээс өмнө угаах тухай анхааруулга.

**7.2** Нарны гэрлийн шууд тусгалаас хамгаалан 60 %-аас багагүй чийгшилтэй өрөөнд халаалтын хэрэгслээс 1 м, хананаас 0,5 м, шалнаас 0,2 м-ээс багагүй өндөртэй зориулалтын тавиур дээр 2 жил хүртэл хугацаанд хадгалж болно.

**7.3** Амны хаалтыг ус, чийг, тоосноос хамгаалж, бүрхүүлтэй тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

**ТӨГСӨВ.**

**ХАВСРАЛТ  
(Мэдээллийн)**

**Амны хаалтны загвар зураг**

